

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/154/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.23 № 01/56
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ХИШИГБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, хэрэгжүүлэх 107 арга хэмжээтэй баталснаас нийт 89,8 хувьтай дүгнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 80,000.0 мянган төгрөгөөр "Нарлаг" хороололд халаалтын шугам татсан, Төрийн албан хаагчдын орон сууц бариулах ажил, албан хаагчдын компьютер, тоног төхөөрөмжийг шинэчлэх зэрэг хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

G/Arkhir/Alban bichig 2024/ A4

019020274

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,598,999.64	150,962,760.64
33	АВЛАГА	5,150,000.00	88,450,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	150,000.00	100,000.00
335	Бусад авлага	5,000,000.00	88,350,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	82,000,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,000,000.00	6,350,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	45,448,999.64	62,512,760.64
354	Хангамжийн материал	45,448,999.64	62,512,760.64
35410	Бичиг хэргийн материал	4,212,860.00	4,309,920.00
35420	Аж ахуйн материал	28,803,439.64	40,926,640.64
35430	Сэлбэг хэрэгсэл	53,000.00	53,000.00
35470	Бусад хангамжийн материал	12,379,700.00	17,223,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,068,085,421.39	1,121,186,459.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,068,085,421.39	1,121,186,459.58
392	Биет хөрөнгө	1,020,376,004.75	1,073,477,042.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	961,234,536.84	1,131,225,798.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	(385,628,019.71)	(430,282,340.06)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	401,611,392.84	401,611,392.84
39204	Хуримтлагдсан элэгдэл	(124,771,327.44)	(191,302,067.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	156,620,408.60	175,251,408.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(137,794,249.66)	(144,755,662.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,479,102.29	36,014,738.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,281,748.98)	(27,508,675.66)
39214	Бусад үндсэн хөрөнгө	266,818,421.00	287,318,421.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(130,912,511.03)	(164,095,970.41)
393	Биет бус хөрөнгө	47,709,416.64	47,709,416.64
39301	Програм хангамж	628,917.00	628,917.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(628,917.00)	(628,917.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	49,089,000.00	49,089,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,379,583.36)	(1,379,583.36)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,118,684,421.03	1,272,149,220.22
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,706,031.00	10,761,248.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,706,031.00	10,761,248.50
413	Өглөг	1,706,031.00	10,761,248.50
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,706,031.00	10,761,248.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,116,978,390.03	1,261,387,971.72
51	Засгийн газрын хувь оролцоо	1,116,978,390.03	1,261,387,971.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	371,408,675.13	371,408,675.13
51101	Өмч: - төрийн	371,408,675.13	371,408,675.13
512	Хуримтлагдсан үр дүн	473,975,301.17	618,451,490.36
51210	Өмнөх үеийн үр дүн	473,975,301.17	474,041,908.67
51220	Тайлант үеийн үр дүн	-	144,409,581.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	271,594,413.73	271,527,806.23
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,118,684,421.03	1,272,149,220.22

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	793,422,348.61	918,976,496.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	209,461,816.00	159,251,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	209,461,816.00	159,251,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		30,000,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		30,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө	-	103,881,600.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	25,370,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	583,960,532.61	789,724,896.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	132,896,026.00	205,268,196.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	83,018,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,677,526.00	205,268,196.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,200,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	451,064,506.61	584,456,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	451,064,506.61	584,456,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	516,779,715.24	775,700,249.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	501,801,451.24	775,700,249.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	475,551,752.57	758,924,191.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,354,034.94	367,943,915.77
210101	Үндсэн цалин	182,354,034.94	277,962,860.84
210102	Нэмэгдэл	-	86,176,442.76
210104	Урамшуулал	-	3,804,612.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,454,419.59	46,084,718.31
210201	Тэтгэврийн даатгал	15,563,126.12	32,013,125.56
210202	Тэтгэмжийн даатгал	1,510,717.68	3,748,371.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,067,735.88	2,932,697.38
210204	Ажилгүйдлийн даатгал	272,837.31	671,858.87
210205	Эрүүл мэндийн даатгал	4,040,002.60	6,718,664.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,564,605.39	98,827,330.90
210301	Гэрэл, цахилгаан	11,697,745.39	12,385,657.40
210302	Түлш, халаалт	67,170,360.00	86,086,673.50
210303	Цэвэр, бохир ус	696,500.00	355,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,513,706.00	44,223,329.72
210401	Бичиг хэрэг	1,931,950.00	3,881,440.00
210402	Тээвэр, шатахуун	18,011,956.00	18,679,247.00
210403	Цуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,225,400.00	1,949,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,956,300.00	9,006,623.72
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,432,000.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,956,100.00	10,706,219.00
2105	Нормативт зардал	638,050.00	1,500,200.00
210502	Хоол, хүнс	402,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	236,050.00	1,500,200.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,439,500.00	5,863,880.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,926,500.00	-
210604	Урсгал засвар	513,000.00	5,863,880.00
2107	Томилолт, зочны зардал	3,499,000.00	7,966,000.00
210702	Дотоод албан томилолт	3,499,000.00	7,966,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,531,287.02	5,991,218.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,635,679.02	5,849,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	195,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	168,608.00	142,168.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,557,149.63	180,523,599.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,314,145.00	22,719,040.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	58,243,004.63	157,804,559.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,249,698.67	16,776,057.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,577,800.00	4,960,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,966,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,611,300.00	4,960,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,671,898.67	11,816,057.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,671,898.67	140,487.56
213405	Нэмэлт санхүүжилт Төвлөрүүлэх шилжүүлэг	-	11,675,570.24
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,978,264.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	14,978,264.00	-
221001	Их засвар	14,978,264.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	276,642,633.37	143,276,246.48
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	6,350,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	6,350,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	33,500.00	5,216,664.79
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	33,500.00	5,216,664.79
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(33,500.00)	1,133,335.21
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	276,609,133.37	144,409,581.69

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	583,960,532.61	789,724,896.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		30,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		30,000,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		30,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	583,960,532.61	759,724,896.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	132,896,026.00	205,268,196.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	83,018,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,677,526.00	205,268,196.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,200,000.00	-

/төгрөгөөр/

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	451,064,506.61	554,456,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	451,064,506.61	554,456,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	444,880,339.22	594,901,234.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	444,880,339.22	594,901,234.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	419,084,640.55	578,125,176.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,348,057.04	367,893,915.77
210101	Үндсэн цалин	140,363,125.13	277,962,860.84
210102	Нэмэгдэл	33,984,931.91	86,176,442.76
210104	Урамшуулал	-	3,754,612.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,446,019.49	46,084,718.31
210201	Тэтгэврийн даатгал	15,602,498.07	32,013,125.56
210202	Тэтгэмжийн даатгал	1,797,329.62	3,748,371.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,397,540.15	2,932,697.38
210204	Ажилгүйдлийн даатгал	323,271.91	671,858.87
210205	Эрүүл мэндийн даатгал	3,325,379.74	6,718,664.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,980,266.00	88,066,082.40
210301	Гэрэл, цахилгаан	10,113,406.00	12,385,657.40
210302	Түлш, халаалт	67,170,360.00	75,325,425.00
210303	Цэвэр, бохир ус	696,500.00	355,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,342,700.00	32,927,923.72
210401	Бичиг хэрэг	2,047,000.00	2,495,500.00
210402	Тээвэр, шатахуун	16,333,800.00	16,385,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,225,400.00	1,949,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,736,500.00	12,097,523.72
2105	Нормативт зардал	699,800.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	699,800.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,493,620.00	9,700,000.00
210604	Урсгал засвар	1,493,620.00	9,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,887,000.00	7,966,000.00
210702	Дотоод албан томилолт	3,887,000.00	7,966,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,308,360.02	5,991,218.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,524,752.02	5,849,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	195,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	168,608.00	142,168.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,578,818.00	18,495,318.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,578,818.00	18,495,318.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,795,698.67	16,776,057.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,123,800.00	4,960,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,966,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,157,300.00	4,960,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,671,898.67	11,816,057.80

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,671,898.67	140,487.56
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	11,675,570.24
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	139,080,193.39	194,823,662.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	139,080,193.39	194,823,662.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	139,080,193.39	194,823,662.00
2200	Дотоод эх үүсвэрээр	139,080,193.39	194,823,662.00
222001	Тоног төхөөрөмж	-	450,000.00
223001	Бусад хөрөнгө	31,805,193.39	82,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	107,275,000.00	112,373,662.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(139,080,193.39)	(194,823,662.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	371,408,675.13	271,860,453.73	218,999,516.2	862,268,645.1
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	265,354.0	265,354.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	371,408,675.13	271,860,453.73	219,264,870.2	862,533,999.1
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	15,884,764.6	15,884,764.6
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	371,408,675.13	271,594,413.73	473,975,301.2	1,116,978,390.0
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	371,408,675.13	271,594,413.73	473,975,301.2	1,116,978,390.0
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	66,607.5	66,607.5
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	371,408,675.13	271,594,413.73	474,041,908.7	1,117,044,997.5
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(66,607.50)	-	(66,607.5)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	144,409,581.7	144,409,581.7
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	371,408,675.13	271,527,806.23	618,451,490.4	1,261,387,971.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	629,880,800.00	584,316,212.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	584,880,800.00	549,402,212.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	579,880,800.00	544,442,212.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	355,982,000.00	341,680,795.92
210101	Үндсэн цалин	295,787,500.00	277,962,860.84
210102	Нэмэгдэл	60,194,500.00	59,963,322.91
210104	Урамшуулал	-	3,754,612.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ШИМТГЭЛ	45,122,800.00	42,948,192.40
210201	Тэтгэврийн даатгал	30,683,400.00	29,769,890.55

210202	Тэтгэмжийн даатгал	3,609,900.00	3,496,193.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,887,900.00	2,730,954.54
210204	Ажилгүйдлийн даатгал	722,000.00	622,850.99
210205	Эрүүл мэндийн даатгал	7,219,600.00	6,328,303.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,795,900.00	88,066,082.40
210301	Гэрэл, цахилгаан	13,407,200.00	12,385,657.40
210302	Түлш, халаалт	89,688,700.00	75,325,425.00
210303	Цэвэр, бохир ус	700,000.00	355,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,965,100.00	32,927,923.72
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,495,500.00
210402	Тээвэр, шатахуун	16,385,100.00	16,385,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,000.00	1,949,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,100,000.00	12,097,523.72
2105	Нормативт зардал	1,000,000.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,700,000.00	9,700,000.00
210604	Урсгал засвар	9,700,000.00	9,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,800,000.00	7,966,000.00
210702	Дотоод албан томилолт	8,800,000.00	7,966,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,515,000.00	5,991,218.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,300,000.00	5,849,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	195,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	142,168.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	14,162,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	14,162,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,000,000.00	4,960,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,000,000.00	4,960,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	4,960,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	45,000,000.00	34,914,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	45,000,000.00	34,914,000.00
222001	Тоног төхөөрөмж	15,000,000.00	14,914,000.00
223001	Бусад хөрөнгө	30,000,000.00	20,000,000.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	629,880,800.00	584,316,212.44
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	599,880,800.00	560,612,212.44
320001	Орон нутгийн төсвөөс	599,880,800.00	560,612,212.44
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	30,000,000.00	23,704,000.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	30,000,000.00	23,704,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00
620001	Удирдах ажилтан	3.00	3.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	132,896,026.00	205,268,196.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	72,896,026.00	45,358,534.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49,268,168.00	33,682,963.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		26,213,119.85
210102	Нэмэгдэл		26,213,119.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,136,525.91
210201	Тэтгэврийн даатгал		2,243,235.01
210202	Тэтгэмжийн даатгал		252,178.58
210203	ҮОМШӨ-ний даатгал		201,742.84
210204	Ажилгүйдлийн даатгал		49,007.88
210205	Эрүүл мэндийн даатгал		390,361.60
2104	Хангамж, бараа материалын зардал	1,044,000.00	
210401	Бичиг хэрэг	1,044,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,224,168.00	4,333,318.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,224,168.00	4,333,318.00
21	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,627,858.00	11,675,570.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,126,500.00	
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,966,500.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,160,000.00	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,501,358.00	11,675,570.24
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,501,358.00	11,675,570.24
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,000,000.00	159,909,662.00
2200	Дотоод эх үүсвэрээр	60,000,000.00	159,909,662.00
223001	Бусад хөрөнгө	60,000,000.00	82,450,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		77,459,662.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	132,896,026.00	205,268,196.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	132,896,026.00	205,268,196.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	132,896,026.00	205,268,196.00

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газар нь төрийн хуулийг дээдлэн хүндэтгэж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг тасралтгүй чанартай хүргэж, төр засгийн бодлого шийдвэрийн дагуу орон нутгаа хөгжүүлэх, иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах, сурч боловсрох, эрүүл аж төрөх нөхцөлөөр хангах чиг үүрэг бүхий аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагааныхаа чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,
- Нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, хэрэгжүүлэх 107 арга хэмжээтэй баталснаас нийт 89,8 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газарт дотоод аудитын нэгж байхгүй ба Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Сумын Засаг даргын 2022 оны А/02 дугаар захирамжаар дотоод хяналт, шалгалтын ажлын хэсгийг байгуулж үйл ажиллагаа явуулж байгаа боловч байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газарт аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь 2013 онд батлагдсан 4 бүлэг 71 зүйлтэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 153,464.8 мянган төгрөгөөр буюу 13,7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	5,150.0	88,450.0	83,300.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	45,449.0	62,512.8	17,063.8
Үндсэн хөрөнгө	1,068,085.4	1,121,186.5	53,101.0
Нийт хөрөнгө	1,118,684.4	1,272,149.2	153,464.8
Өр төлбөр	1,706.0	10,761.2	9,055.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,116,978.4	1,261,388.0	144,409.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,118,684.4	1,272,149.2	153,464.8

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд авлага дансны эцсийн үлдэгдэл 88,450.0 мянган төгрөг болж өссөн нь төрийн албан хаагчдын орон сууцны барилгын ажлыг хүлээлцээгүй байгаа тул олгосон санхүүжилтийн дүнгээр авлага үүсгэснээс шалтгаалсан байна.

Бараа материал дансны хувьд бичиг хэргийн материал 97,060.0 мянган төгрөг, аж ахуйн материал 12,123,201.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 4,843,500.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, мал амьтад 5,000,000.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс барилга байгууламж, орон сууц 169,991.0 мянган төгрөг, машин тоног

төхөөрөмж 18,631.0 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 20,500.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 7,464.0 мянган төгрөг, шилжүүлсэн 133.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 97,910.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 14,464.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 72,082.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 4,300.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 27,500.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Өглөг дансны эхний үлдэгдэл 1,706.0 мянган төгрөг байсан бол оны эцсийн үлдэгдэл 10,761.0 мянган төгрөг болж 9,055.2 мянган төгрөгөөс өссөн нь түлш халаалтын өглөг үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,261,388.0 мянган төгрөг болж 144,410.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 652,666.9 мянган төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 30,000.0 мянган төгрөг, нийт эх үүсвэрийг 682,666.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 52,786.1 мянган төгрөгөөр бууруулж 2023 оны урсгал зардлын төсвийг 629,880.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 629,880.8 мянган төгрөгөөс төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 584,456.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 584,316.2 мянган төгрөгийг зарцуулж 140.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 584,316.2 мянган төгрөг буюу 92,7 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Үндсэн үйл ажиллагааны зардал	505,892.90	472,635.42	33,257.48	93.4
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Баг, хорооны үйл ажиллагааны зардал	46,887.90	45,683.38	1,204.52	97.4
3	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	5,000.00	4,960.00	40.00	99.2
4	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Бусад	45,000.00	34,777.80	10,222.20	77.3
5	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Засгийн газрын нөөц хөрөнгө	10,000.00	9,162.00	838.00	91.6
6	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Улсын их баяр наадам	5,000.00	5,000.00	-	100.0
7	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	12,100.00	12,097.60	2.40	100.0
	Дүн	629,880.80	584,316.20	45,564.60	92.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд мал тооллогын зардал 383.3 мянган төгрөг, ковшийн ажлын хөлс 3,000.0 мянган төгрөг, сумын төвийн цахилгаан шугам сүлжээ дэд станцын хүчин чадлыг өргөтгөх ажлын захиалагчийн хяналтын зардал 1,500.0 мянган төгрөг, нийт 132,896.0 мянган төгрөгийн орлого орсноос тээвэр шатахуунд 1,044.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 48,224.1 мянган төгрөг, тэтгэмжид 17,966.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 4,160.0 мянган төгрөг, автомашин худалдан авахад 60,000.0 мянган төгрөг, төрийн албан хаагчийн орон нутгийн нэмэгдэл цалингийн санхүүжилт 32,475.2 мянган төгрөг, гэр хорооллын айл өрхүүдийг нэгдсэн халаалтад холбох ажлын санхүүжилт 77,909.6 мянган төгрөг, төрийн албан хаагчийн орон сууцны санхүүжилт 90,000.0 мянган төгрөг, нийт 205,268.2 мянган төгрөгийн орлогын төвлөрүүлж, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд 29,349.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 4,333.3 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 159,909.6 мянган төгрөг, нийт 193,592.6 мянган төгрөгийг зарцуулж, 11,592.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Хөтөлбөр 89,8 %	629,880.8	584,316.2

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр урсгал зардал болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар 186,761.2 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 186,761.2 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Харин зарим шууд худалдан авалтыг хийхдээ цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны 06/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Баянхангай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газрын батлагдсан 2023 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 793,422.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 11,901.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,926.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Шилэн дансны цэсэд мэдээлбэл зохих 171 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроосон 1 мэдээллийг мэдээлээгүй байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 30, зарлагын 7 гүйлгээ, хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх 95,460.2 мянган

төгрөгийн 24 гүйлгээг хуулийн хугацаанд мэдээлсэн байна. Худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын тамгын газарт 2023 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 4 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж, 2 албан шаардлага өгснийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 06/30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	105,411.9	2	105,411.9	100%
Зөвлөмж	1	47,275.0	1	47,275.0	100%
Нийт дүн	3	152,686.9	3	152,686.9	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар урьдчилгаа, авлага, цалингийн өглөгийн бичилтүүдийг авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нийт 18,823.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

Тайлант хугацаанд 18,823.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл бодоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.1 Төлбөрийн акт

Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн “Төрийн албан хаагчдын ангилал зэрэглэл, цалин хөлсийг шинэчлэн тогтоож, орон нутгийн нэмэгдэл олгох тухай” Б/02 тоот захирамж, Сумын засаг даргын Б/02 дугаар захирамжуудаар улс төрийн 5 албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл цалинд 7,685.7 мянган төгрөг олгосон зөрчил илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 тоот тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага бичигдээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Өглөг, авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын татварын тодорхойлолтоор 671.2 мянган төгрөгийн өмнөх оны татварын илүү дутуу төлөлт, автомашины торгуулийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Байгууллагын эзэмшилд байгаа тээврийн хэрэгслүүдийн өмнөх онуудын торгуулийг зөрчил гаргасан этгээдээр төлж барагдуулах, татварын тодорхойлолтод байгаа илүү дутуу төлөлтүүдийг татварын байцаагчтай тооцоо нийлж барагдуулах.

Дээрх төлбөрийн акт, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу бодогдсон	1	18,823.8	1	18,823.8			1	18,823.8				
Дүн	1	18,823.8	1	18,823.8			1	18,823.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
									Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Улс төрийн албан тушаалтнуудад орон нутгийн нэмэгдэл олгосон.	1	7,685.8	1	7,685.8								
Байгууллагын татварын тодорхойлолтоор өмнөх оны татварын илүү дутуу төлөлт, автомашины торгуулийн үлдэгдэлтэй	1	671.2					1	671.2				
Дүн	2	8,357.0	1	7,685.8			1	671.2				

